



Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



2026 он

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:



Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал болон Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.



2025

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ



11,544.4

сая төгрөг

БАТЛАГДСАН
САНХҮҮЖИЛТ



62

ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭ



Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний ангилал:

- ⇒ Барилга байгууламж 2 ажил
- ⇒ Авто зам, дэд бүтэц 3 ажил
- ⇒ Их засвар, тохижилт 35 ажил
- ⇒ Тоног төхөөрөмж авах 16 ажил
- ⇒ Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бусад 6 ажил

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл
/сая төгрөг/

№	Тендер шалгаруулалтын арга	ИТХ-аар батлагдсан		ХАА зохион байгуулсан		Хэрэгжээгүй ТАХ	
		Төсөвт өртөг	Ажлын тоо	Төсөвт өртөг	Ажлын тоо	Төсөвт өртөг	Ажлын тоо
1	Нээлттэй	8,530.0	24	8,448.7	21	769.4	3
2	Харьцуулалт	2,864.7	31	1,923.2	25	587.3	6
3	Шууд	149.7	7	90.6	4	59.0	3
Нийт		11,544.4	62	10,462.4	50	1,416.2	12

Гэрээ байгуулагдсан ажлын гүйцэтгэл

(сая.төгрөг)

№	Гэрээ байгуулсан ажил	Гэрээ байгуулсан ажил		Үүнээс: хэрэгжсэн		Гүйцэтгэлийн хувь
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
1	Авто зам, дэд бүтцийн	8	1,982.8	6	1,655.3	75.0
2	Барилга, байгууламж	1	1,570.0			0.0
3	Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бусад	9	4,185.5	4	3,226.3	44.4
4	Их засвар, тохижилтын	26	4,220.4	19	2,482.9	73.1
5	Тоног төхөөрөмж	10	1,301.3	10	1,301.3	100.0
6	Тээврийн хэрэгсэл	6	841.1	6	841.1	100.0
	ДҮН	60	14,101.1	45	9,506.9	75.0

Төсөл арга хэмжээний гэрээ, санхүүжилт

(сая.төгрөг)

Эх үүсвэр	Батлагдсан төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн		Санхүүжилт олгосон	
			ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
Шилжих үлдэгдэл	28	5,930.7	36	9,661.8	19	3,129.7
Их засвар	6	1,933.7	6	1,633.6	5	1,589.3
Авто замын сангийн хөрөнгө	18	2,360.0	18	2,805.7	13	1,797.1
Нийт дүн	52	10,224.4	60	14,101.1	37	6,516.1



Аудитаар илэрсэн зөрчилд 24.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 4,367.3 сая төгрөгийн 8 албан шаардлага, 3 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүллээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- ⇒ Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд нь аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй нийцсэн байна.
- ⇒ Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөсөн ажлуудыг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу эрэмбэлэх, үнэлэх ажил хийгдэхгүй байна.
- ⇒ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан зарим ажлууд зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй байна.
- ⇒ Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хяналтын төсөвгүй тендер зарлах зөрчил давтагдсаар байна.
- ⇒ Тайлант хугацаанд хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл 75,0 хувьтай байна.
- ⇒ Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлууд бүрэн хэрэгжээгүй нь зураг, төсөвгүй ажлыг тухайн онд хэрэгжүүлэхээр баталснаас шалтгаалсан байна.
- ⇒ Тайлант онд хэрэгжүүлсэн 52 төсөл, арга хэмжээнд 10,224.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдаж 60 иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулснаас 23 гүйцэтгэгчид санхүүжилт олгоогүй байна.
- ⇒ Тайлант онд хэрэгжиж дууссан 2,436.7 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн аймгийн Засаг дарга танаа зөвлөх нь:

- ⇒ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар хийгдсэн ажлыг тусган батлуулж байх, зураг төсөвгүй ажлыг батлахгүй, санхүүжүүлэхгүй байх
- ⇒ Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах,
- ⇒ Батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хугацаанд нь чанартай хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах